



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

“Удирдах зөвлөл болон төлөөлөн удирдах
зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүдийг томилох
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх зүйл, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1, “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүдийг хавсралт ёсоор томилсугай.

2. Томилогдсон гишүүдэд Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”, “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100062

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД
ТОМИЛОХ ГИШҮҮДИЙН НЭРС

| № | Байгууллагын нэрс | Томилогдох гишүүдийн нэр | Одоо эрхэлж байгаа албан тушаал |
|---|--|--------------------------|--|
| 1 | Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ | Ц.Төрхүү | Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга |
| | | Л.Хосбаяр | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| 2 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ | Д.Энхбаяр | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Б.Нэргүй | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| 3 | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ | Б.Гантулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Тасгийн дарга |
| | | Д.Амгалан | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| 4 | Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ | В.Оюумаа | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | | Б.Энхжин | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| 5 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | Б.Загарсүрэн | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тасгийн дарга |
| | | Н.Отгонбаяр | Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга |
| 6 | Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ | Б.Мөнхцэцэг | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Ү.Ганболд | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | | М.Балдандорж | Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга |
| 7 | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж | Б.Сэргэлэнбаатар | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Х.Гантулга | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга |
| | | П.Хадбаатар | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | | Л.Бямбасүрэн | Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | | Б.Мөнх-Эрдэнэ | Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын, удирдлагын хэлтсийн дарга |

| | | | |
|----|--|----------------|---|
| 8 | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК | Д.Цолмон | Нийслэлийн Засаг даргын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх |
| | | Д.Амгалан | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | | В.Оюумаа | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| 9 | Улаанбаатар спорт менежмент ХК | Г.Батжаргал | Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 10 | Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ХХК | Д.Энхбаяр | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Л.Эрдэнэбадрах | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Тасгийн дарга |
| 11 | Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК | Т.Отгонболд | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Б.Мөнхцэцэг | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | О.Мөнхтуяа | Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | | Б.Солонго | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга |
| | | Б.Адъяа | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 12 | Улаанбаатар смарт карт ХХК (нийслэлийн мэдлийн 24%) | Л.Ариунтуяа | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Ш.Шадвийдорж | Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Санхүү, аж ахуйн тасгийн дарга |
| 13 | Эрдэнэс Баянбогд ХХК | Н.Батсүмбэрэл | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| 14 | Хишиг-Уул ХК | С.Сэржжаргал | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Хувьчлал хариуцсан ахлах мэргэжилтэн |
| 15 | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ | Л.Ариунтуяа | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Г.Батжаргал | Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | | Б.Загарсүрэн | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тасгийн дарга |
| 16 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ | Л.Ариунтуяа | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |
| | | Д.Ихбаяр | Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгч |

